

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 65.020.40

Цэцэрлэгжүүлсэн талбайг шалгаж, ашиглалтад хүлээн авах. Ерөнхий шаардлага	MNS 6263 : 2011
Checking garden objects and accept for use it. General requirement	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2011 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлав.

Энэ стандартыг улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн мөрдөнө.

1 Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь хот суурин газрын цэцэрлэгжүүлсэн талбайг шалгаж, ашиглалтад хүлээн авахад хамаарна.

2 Норматив ишлэл

Энэхүү стандартад дараах баримт бичгийг иш татсан бөгөөд эдгээр стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны материалаас иш татаж хэрэглэнэ.

- MNS 6139 : 2010, Шилмүүст төрлийн модны суулгац. Техникийн шаардлага,
- MNS 6141 : 2010, Навчит төрлийн модны суулгац. Техникийн шаардлага,
- ГОСТ 24835-81, Мод, сөөгний суулгац. Техникийн шаардлага,
- ГОСТ 24909-81, Навчит төрлийн модны суулгац. Техникийн шаардлага,
- ГОСТ 25769-83, Шилмүүст төрлийн модны суулгац. Техникийн шаардлага,
- ГОСТ 26869-86, Сөөгний суулгац. Техникийн шаардлага.

3 Нэр томъёо, тодорхойлолт

3.1

Мод

Титэм бүхий гол иштэй модлог ургамал,

3.2

Сөөг

Гол ишгүй, үндэсний хүзүүнээс дээш адил хэмжээний олон иштэй, 5 м хүртэл өндөр ургадаг модлог ургамал,

3.3

Тарьц

Мод үржүүлгийн газарт үр болон мөчрөөр ургуулсан 1-ээс 2 настай модлог ургамал,

3.4

Суулгац

Бойжуулгын талбайд шилжүүлэн суулгаж, ургуулсан 2-оос дээш настай модлог ургамал.

4 Техникийн шаардлага

4.1 Бэлтгэл ажил

Цэцэрлэгжүүлсэн талбайг ашиглалтанд хүлээлгэж өгөхөд гүйцэтгэгч байгууллагаас дараах материалыг бэлтгэнэ.

- а. Цэцэрлэгжүүлэлтийн ажлын зураг,
- б. Ажлын тайлан (А хавсралт),
- в. Тарилтын маягт (В хавсралт),
- г. Цэцэрлэгжүүлсэн талбайг хүлээлгэн өгсөн акт (С хавсралт)

4.2 Цэцэрлэгжүүлсэн талбайг хүлээлгэн өгөхийн өмнө талбайн хог хаягдлыг цэвэрлэж, хавтан зам талбайг элсээр чигжиж нягтруулан, мододыг бэхэлж, тогоог гаргасан байна.

4.3 Цэцэрлэгжилтийн ажлын зураг нь тухайн талбайг тохижуулахад гүйцэтгэсэн ажлыг тооцох тулгуур материал бөгөөд ажлын зураг өөрчлөгдвөл архитекторч зохиогчтой тохиролцсоны үндсэн дээр гарсан өөрчлөлтийг ажлын гүйцэтгэлийн зураг дээр тодорхой тэмдэглэнэ.

5 Хүлээлцэх хугацаа

5.1 Цэцэрлэгжүүлсэн талбайг комиссоос 8 дугаар сарын 15-аас 20-ны хооронд шалгаж үнэлгээ, холбогдох санал өгч, дараа жилийн 10 дугаар сарын 15 хүртэл хугацаанд хүлээн авна.

5.2 Мод, зүлгийг хүлээн авах хүртлэх хугацааны арчилгаа тордолтыг гүйцэтгэгч албан байгууллага бүрэн хариуцна.

5.3 Цэцэрлэгжүүлсэн талбайг ашиглалтад хүлээн авах хугацааг дараах тохиолдолд хойшлуулах эрхийг комисс эдэлнэ.

5.3.1 Гүйцэтгэгч байгууллагаас хүлээлгэн өгөх материалын аль нэг нь дутуу, буруу хийсэн байх,

5.3.2 Услах боломжоор хангаагүй,

5.3.3 Ажлын чанар нь холбогдох стандартын шаардлагыг хангаагүй, зураг төсөл зөрчигдсөн байх.

6 Хүлээн авах

6.1 Цэцэрлэгжүүлсэн талбайг шалгаж ашиглалтад хүлээн авах баг нь гүйцэтгэгч байгууллагаас хүлээлгэн өгөхөд бэлтгэсэн баримт материалыг үндэслэн газар дээр нь тооллого, хэмжилт хийж, ажлын зураг, стандартын шаардлага хангаж буй эсэхийг тогтоож хүлээн авна.

6.2 Суулгасан мод, сөөг нь MNS 6139 : 2010, MNS 6141 : 2010, MNS 6140 : 2010, MNS 6255 : 2011, MNS 6256 : 2011, MNS 6257 : 2011 стандартуудын шаардлагыг хангасан байна.

6.3 Мод, сөөгний суулгацыг MNS 6258-2 : 2011 стандартын дагуу арчилна. Хэрвээ суулгасан мод, сөөг нь стандартын шаардлага хангаагүй, мөчир нь хугарсан, ургаагүй бол нөхөж суулгана.

6.4 Зүлэгжүүлсэн талбайд зүлэг жигд ургасан байна. Хэрвээ ургаагүй буюу хэт сийрэг тарьсан бол нөхөн тарилтыг хийсэн байна.

6.5 Ажлын чанар, гүйцэтгэлийг шалгасан материалд үндэслэн тухайн талбайг ашиглалтанд хүлээн авсан тухай акт (“С” ХАВСРАЛТ) үйлдэж, ажлын чанар, хэмжээг тусгана.

6.6 Гүйцэтгэсэн ажил дутуу хийсэн тохиолдолд хугацаа хойшлуулах шаардлагатай гэж үзвэл актын төгсгөлд тусгайлан тэмдэглэж, гүйцэтгэх хугацааг заана.

6.7 Цэцэрлэгжүүлэлтийн ажлын гүйцэтгэл сайн, онц дүнтэй бол хүлээж авна.

ТӨГСӨВ.

“А” ХАВСРАЛТ
(Норматив)

201... онд-ыг цэцэрлэгжүүлсэн
(талбайн нэр)

АЖЛЫН ТАЙЛАН

1-р хүснэгт

№	Хийсэн ажлын нэр төрөл	Хэмжих нэгж	Хэмжээ тоо	Үнэ /төг/	Тайлбар
1	Явган хүний зам, талбайд гүйцэтгэсэн ажил	м ²	40		
2	Зүлэгжүүлсэн ажил	м ²	250		
3	Суулгасан мод : - ... настай суулгац - ... настай суулгац г.м.	ш ш	10 15		
4	Суулгасан сөөг: - ...настай суулгац - ...настай суулгац г.м.	ш ш	5 26		
5	Газар шорооны ажил: 1. ...модны нүх ухах 2. ...сөөгний нүх ухах 3. ... шуудуу ухах 4. нүх ухахад гарсан хаягдал чулуу, хогийг зайлуулах 5. шинээр хөрсжүүлсэн талбай	м ³ м ³ м ³ м ³ м ²	8 12 15 18 150		
6	Цэцгийн мандал г.м.	м ²	10		

ТАЙЛБАР: Хүснэгтэн дэх тоог жишээ болгож авсан болно.

Гүйцэтгэгчийн төлөөлж: (.....)

201 ...оны -р сарын өдөр

“В” ХАВСРАЛТ
(мэдээлэл)

ОНД БАЙГУУЛСАН.....ийн
(объектын нэр)

ТАРИЛТЫН МАЯГТ

2-р хүснэгт

Суулгасан мод, сөөг	Тоо /ш /	Өндөр /м/	Үнэ /төг/	Тайлбар
Мод: 1. Гацуур 2. Нарс 3. Улиас г.м. Бүгд				
Сөөг: 1. Голтбор 2. Тавилгана 3. Шар хуайс Бүгд				
Нийт дүн				

Гүйцэтгэгчийг төлөөлж:

(.....)

201 оны - р сарын... өдөр

“С” ХАВСРАЛТ
(норматив)

ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛСЭН ТАЛБАЙГ АШИГЛАЛТАД ХҮЛЭЭН АВАХ АКТ

Улаанбаатар хот № 201.. оны -р сарын ... өдөр

.....нарын

бүрэлдэхүүнтэй комиссоос - аас
(цэцэрлэгжүүлэлтийн ажил гүйцэтгэсэн)

байгууллага (.....) цэцэрлэгжүүлсэн

объектын нэр (.....) - ийг тохижуулсан

ажлыг 201... оны ... -р сарын ...-нд газар дээр нь шалган үзэж, энэхүү актыг үйлдэв.


Нийт м² талбайд дараах үндсэн ажлуудыг гүйцэтгэсэн байна. Үүнд:

Гүйцэтгэсэн ажлын жагсаалт

Ажлын нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Чанар /сурагч үнэлгээгээр/	Тайлбар


Дээр заасан ажлыг холбогдох стандартын шаардлага зураг төслийн дагуу “. . . “ дүнтэй гүйцэтгэсэн гэж үзээд байнгын ашиглалтанд хүлээн авав.

- хавсралт: 1. Цэцэрлэгжүүлэлтийн ажлын зураг хуудас
2. Цэцэрлэгжүүлэлтийн ажлын тайлан хуудас
3. Тарилтын маяг хуудас
4. Гүйцэтгэсэн ажлын жагсаалт, зардал (мян. төг-өөр)




1-р зураг. Суулгацыг суулгах бүдүүвч


1. Титэм; 2. Гувар; 3. Үндсэн мөчрүүд; 4. Нүхний доод үеийн шороо; 5. Нүхний өнгөн үеийн шороо; 6. Шороотой нь авсан үндэс; 7. Үндэсний хүзүүвч; 8. Үржил шимтэй хар шороон хөрс;



2-р зураг. Суулгацыг түр хадгалах байдал



3-р зураг. Суулгацыг ухаж авах



4-р зураг. Суулгацыг машин дээр ачих